

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ НЬ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БОЛОХ НЬ

А.Ажилчин

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын акедимийн 8012 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: Монгол Улсад зөвхөн улсын хил дээр үйл ажиллагаа явуулснаар үндэсний ашиг сонирхолын, тэр тусмаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, түүний хилийн халдашгүй дархан байдлын хамгаалалтыг хангах боломжгүй. Монгол Улсын асуудал болон хилийн асуудал зөвхөн хилийн хоёр талаар өргөн зурваст, өөрөөр хэлбэл хилийн орон зайд хилийн хамгаалалтын бүх субъектуудын идэвхитэй үйл ажиллагааны нөхцөлд амжилттай шийдвэрлэгдэж чадна.

Abstract: In Mongolia, it is not possible to protect national interests, especially territorial integrity and the inviolability of its borders, by operating only on the state border. The issue of Mongolia and the border issue can be successfully resolved only in a wide area on both sides of the border, that is, in the conditions of active activity of all subjects of border protection in the border area.

Түлхүүр үгс: Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хилийн аюулгүй байдал.

Keywords: Mongolias national security, border security.

Оршил:

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх цэрэг-улс төрийн болон эдийн засгийн цагийн байдал манай оронд төдийгүй дэлхий дахинаа сөрөг тал руугаа өөрчлөгдлөө. “Хүйтэн дайны” эрин төгсөж, хоёр туйлт ертөнц утсанаар Монгол Улс болон нийт хүн төрөлхтний ашиг сонирхолд нийцэж, үнэт зүйлсийг бүтээхэд

чиглэгдэнэ гэж төсөөлөгдөж байсан зурвас руу ороогүй төдийгүй харин

эсрэгээр санамсаргүйгээр хувь хүн, нийгмийг хүчирхийлэх шинэ гал авалцаж, харгис үндсэрхэг үзлийн өрнөл, улс төрийн хийгээд шашны хэт үзэлтнүүдийн идэвхжилтэй тулгарав. Хуучин өөрчлөн байгуулалтын цаг хугацаа нь хилийн хямрал, зөрчилдөөнийг олшруулсан¹⁶.

¹⁶ Ш.Арвай. Хилийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны тулгамдсан зарим асуудал(Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа/Олон улсын эрдэм

шинжилгээний хурлын материал/).УБ.2012 он.

Монгол улс, улс төрийн хямралын эрс тэс дахин ухамсарлалын үе шатын онцлогийг амсаж байгаа шинээр өөрчлөгдөн буй цэрэг-улс төрийн (ялангуяа эдийн засгийн) нөхцөлд гадаад үндсэн аюул заналд дараах зүйлүүд хамаарна:

- Хөрш улсуудаас газар нутгийн маргаан гаргаж болзошгүй;
- Монгол Улсын дотоод хэрэгт оролцох;
- Олон Улсын аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын ашиг сонирхолыг эс хайхрах (хавчих), олон туйлт ертөнцийн нөлөөлөгч төвүүдийн нэг болох түүний бэхжилтэнд саад хийх оролдлого;
- Зэвсэгт мөргөлдөөний голомт, ялангуяа Монгол Улсын хилийн ойролцоо;
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахуйц цэргийн эвсэл, холбооны өргөжилт;
- Монгол Улстай хөрш зэргэлдээх найрсаг харилцааны улсуудын нутаг дэвсгэрт гадаадын цэрэг (НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн зөвшөөрөлгүй) оруулах;
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахын тулд тэдгээрийг илгээх зорилгоор бусад

улсын нутаг дэвсгэр дээр цэргийн анги, салбар, бүлгийг байгуулах, зэвсэглэх, хангах болон бэлтгэх.

Сүүлийн жилүүдэд хурцаар мэдрэгдэж байгаа түгшүүртэй нөхцөл байдал нь “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал”, “Хилийн аюулгүй байдал” гэсэн ойлголтод илүү их анхаарал, болгоомжтой хандах шаардлагатайг сануулсаар байна. Үүнээс гадна Монгол Улсын хилийн алба хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан тодруулах хэрэгтэй нь төсөөлөгдөж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь Монголын тусгаар тогтнол, улс орны дотоодын бүрэн бүтэн байдал, хорлон сүйтгэх хүчин зүйлүүдэд өртөхгүй байх, гадаад, дотоодын аюул занлыг тэсвэрлэх, оршин тогтнох, хөгжих, өөрт нь учрах аливаа халдлагаас улс, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхлыг найдвартай хамгаалах, оршин тогтож хөгжих, цаашид урагшлах чадвартай байх, мөн түүнчлэн дэлхийн хэмжээнд бусад улс орнуудтай амжилттай зохицон, харилцан ашигтай хамтран ажиллах зэргийг баталгаажуулах ийм өөрийн улс, үндэсний байдлыг илэрхийлдэг.

Монгол Улсын нутаг дэвсгэрт харийнхан чөлөөтэй нэвтрэх боломжийг олгож, зохион байгуулалттай гэмт хэргийг өөгшүүлэн, мансууруулах бодисын

бизнесийг сонирхогчид илүү таатай нөхцлийг бүрдүүлсэн. Энэ үед дэлхийд нэг хүн амд ногдох нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ бараг эхний байранд ордог, дэлхийн хэмжээнд хаанчлагч гурван гүрний хоёрын нь дунд оршдгийг тооцох шаардлагатай.

Хөрш зэргэлдээх улсуудтай хиллэж байгаа улсын хилийн хэсэг бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоос үүдэн тухайн чиглэлд хилийн аюулгүй байдлыг хангах арга, үйл ажиллагаа онцлогтой.

Энэхүү нөхцөл байдлын зайлшгүй чухал байдал нь дэлхийн бодлогыг тодорхойлогч гурван их гүрний нэг Оросын Холбооны Улстай тодорхойлон, тогтоож хэд хэдэн удаа тодотгосон хилээ Нэгдсэн Үндэсний Байгууллагаар баталгаажуулаагүйд оршино. Нөгөө талаас ОХУ-тай хиллэсэн хэсгийн гадна Монгол туургатангууд оршин амьдарч байгаа явдал юм. Хэдийгээр одоохондоо газар нутгийн маргаан, зэвсэгт мөргөлдөөн гараагүй хэдий ч хэзээ нэгэн цаг үед гарахгүй гэх магадлал байхгүй. Иймд энэ бүх асуудлыг урьдчилан бодолцож, төрийн хар хайрцагны бодлогын багцад барьж, бэлэн байх нь нэн чухал.

Харамсалтай нь Монгол Улсын, Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-д “Улсын хилийн аюулгүй байдал” бүрэн томъёологдоогүй

бөгөөд харин түүний хангалтыг төрийн хилийн бодлогын чиглэлүүдийн нэгэнд л хамаатуулсан. Мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь улс орны нэгдмэл байдал, түүний оршин буй нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалан, бэхжүүлдэг. Үндэсний аюулгүй байдал шиг хилийн аюулгүй байдлын төрлүүд нь улсын хилийн хамгаалалтад оролцож байгаа хүч, хэрэгслүүдийн үйл ажиллагааны нутаг дэвсгэр-орон зайн хүчин зүйлээр бус, харин улс оронд учирч байгаа буюу учирч болзошгүй аюул заналын төрлүүдээр тодорхойлогддог. Үүнтэй уялдан улсын хилийн аюулгүй байдлыг бүрэлдүүлж буй чухал төрлүүд нь үндэсний аюулгүй байдлын улс төр, эдийн засаг, цэрэг, экологи, оюун санааны болон бусад төрлүүд болно. Түүнчлэн үндэсний болон хилийнаюулгүй байдлын бүтцийн маргаангүй харьцуулалт нь энэ хоёр аюулгүй байдал адилхан үндэстэйг харуулж байна.

Харин Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйлд **“Монгол Улсын хилийн аюулгүй байдал”-ын талаар доорх байдлаар тусгасан байна. Үүнд:**

- Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /Цаашид “хилийн аюулгүй байдал” гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.

- Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг

дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ.

- Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

- Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна.¹⁷ хэмээн тусгасан.

Нөгөө талаар, хилийн аюулгүй байдал гэж улсын амин чухал ашиг сонирхлын хамгаалагдсан байдал, бүх нийгмийн болон байгууллага-тусгай бүтцийн итгэл үнэмшилтэй оршин тогтнол, үйл ажиллагаа мөн түүнчлэн энэ орон зайд хувь хүний хийгээд нийгмийн хамгаалагдсан байдал хангагдсан байх улсын хил дээрх болон хилийн орон зай дахь цэрэг-улс төрийн ба оперативын цагийн байдлын ийм нөхцлийг хэлнэ.

Өнөөдөр Монгол Улсад зөвхөн улсын хил дээр үйл ажиллагаа явуулснаар үндэсний ашиг сонирхолын, тэр тусмаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, түүний хилийн халдашгүй дархан байдлын хамгаалалтыг хангах боломжгүй. Монгол Улсын асуудал болон хилийн асуудал зөвхөн хилийн хоёр талаар өргөн зурваст, өөрөөр хэлбэл хилийн орон зайд хилийн хамгаалалтын бүх субъектуудын идэвхитэй үйл ажиллагааны нөхцөлд амжилттай шийдвэрлэгдэж чадна.

Өнөө үед Монгол Улсын хилийн орон зайд нийт үндэсний шинжтэй үндсэн асуудал, хүндрэл, зөрчилдөөн төвлөрсөн гэхэд хилсдэхгүй.Зэвсэгт болон шашны зөрчилдөөн, салан тусгаарлах үзэл, улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд учирч болзошгүй аюул занал, эдийн засгийн хийгээд хүн ам зүйн түрэмгий бодлого, гадаад дарамтын янз бүрийн төрлүүд (улс төрийн, эдийн засгийн болон бусад), хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүн ам зүйн хөдөлгөөн болно.Түүнчлэн байгалийн эрс эргэлт (газар хөдлөлт, усны үер, гоц халдварт өвчин гэх мэт) явагдах болсон.Энэ нь гаж буруу буюу хачин зүйл биш бөгөөд үндсэндээ манай улсын хилийн дагуу гарч байна¹⁸.

¹⁷Монгол Улсын Хилийн тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2017 он №06.

¹⁸Д.Нямдорж.Улсын хилийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд, системийн онолтой холбогдох нь(Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа

Улсын хил дээрх цэрэг-улс төрийн болон оперативын цагийн байдлын ямар ч нөхцөлд хилийн аюулгүй байдлын найдвартай байдлын үндсэн хүчин зүйл нь юуны өмнө хилийн аюулгүй байдалд шууд нөлөөлж буй улсын хилийн хамгаалалтынхилийн цэргийн хийгээд бусад субъектуудын хүч хэрэгслийн бүс нутгийн бүлэглэлийн хүчин чадал, хилийн орон зайд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд болон хувь хүн, нийгэмд учрах аюул заналыг цаг тухайд нь илрүүлэх, түүнийг эрчимтэй саармагжуулах, таслан зогсоох ба няцаах явдал юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах явдал нь төрийн үйл ажиллагааны чухал үндсэн чиглэл юм.Эцсийн дүндээ, хилийн аюулгүй байдал нь улсын хилийн хамгаалалтад оролцож буй субъектуудын системийн үйл ажиллагаагаар хангагдана.

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн

болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ”.¹⁹ гэж Хилийн тухай хуульд тусгасан. Үндсэндээ энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх системийн хэсэг болох улсын хилийн хамгаалалт нь улс төр, зохион байгуулалт-эрх зүй, дипломат, эдийн засаг, батлан хамгаалах, тагнуул, оператив-эрэл тагнуул, гааль, байгаль орчин, ариун цэвэр-халдвар судлал,экологийн болон бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын төрийн эрх мэдлийн байгууллагууд, субъектуудын болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад оршино²⁰.

Улсын хилийн хамгаалалт нь хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхолыг хангах бөгөөд түүнийг Монгол Улсын хуулиар тогтоосон бүрэн эрхийнхээ дагуу гүйцэтгэх засаглалын бүх байгууллагууд хэрэгжүүлнэ.

/Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал/.УБ.2012 он.

¹⁹Монгол Улсын Хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он №06.

²⁰ Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он.

Улсын хил хамгаалах арга хэмжээ нь хилийн арга хэмжээ байна. Хилийн арга хэмжээ нь улс, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхолд учирч болзошгүй холбогдох аюул заналын болон хилийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн хилийн бодлогын хүрээнд хэрэгжих, аюулгүй байдлын арга хэмжээнүүдийн системд ордог.

Монгол Улсын Засгийн газар үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах гүйцэтгэх засаглалын эрх мэдлийн байгууллагуудыг удирдана.

Хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар хариуцна. Энэ утгаараа хил хамгаалах ерөнхий газар нь улсын хил дээр болон хилийн орон зайд улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн цэрэг, байгууллагуудын хийгээд өөрөө удирдах ёсны байгууллагуудын системийг тэргүүлдэг. Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад Монгол Улсын хил хамгаалах ерөнхий газрын үүрэг роль аугаа. Ерөнхий утгаараа энэ нь доорхи байдлаар илэрхийлэгдсэн:

- Бүх хэрэгслийн, ялангуяа цэргийн хийгээд Монгол Улсын нутаг дэвсгэрийн тусгаар тогтнолын болон улсын хилийн шугамын явалтын хууль бус өөрчлөлтийг гаргуулахгүй байх.

- Улсын хилийн дэглэмийг болон хилийн журмын бусад төрлүүдийг сахиулахад.

- Улсын хилийн зөрчил гаргуулахгүй, зэвсэг, сум галт хэрэгсэл, тэсрэх дэлбэрэх болон хордуулах бодис, хар тамихыг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, дамын наймааны хийгээд бусад хууль бус үйл ажиллагааны сувгуудыг илрүүлэх ба хаах.

- Улсын хил дээр болон хилийн орон зайд төвлөрч буй Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй бусад олон тооны аюул заналыг гаргуулахгүй байх ба устгах, ялангуяа улсын үндэсний баялгийг хулгайлах болон дээрэмдэх явдлыг таслан зогсооход.

- Хил дээр болон хилийн орон зайд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолыг найдвартай хамгаалахад.

- Бүх орон зайд Монгол Улсын геополитикийн байр суурийг хадгалах, бэхжүүлэх.

- Хилийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд болон сайн хөршийн харилцааг хөгжүүлэхэд нөлөөлөх хилийн диломатыг хэрэгжүүлэхэд.

- Тивийн эх газар дээр болон эдийн засгийн бүсэдолдвор, хайгуулын үйл ажиллагаанд хяналт тавихад.

- Монгол Улсын хилийн орон зайд дотоод улс төрийн тогтвортой байдлыг хангах, гарч болзошгүй зөрчилдөөний галын дөлийг бүслэн хаах, үндсэн хуулийн журмыг сэргээн сахиулах зайлшгүй шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд.

- Улсын хилийн асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөн түүнчлэн гадаад улс орны хилийн байгууллагуудтай харилцан ажиллахад.

- Монгол Улсын хилийн аюулгүй байдлын зорилгод хүрэхэд чиглэгдсэн бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд.

Монгол Улсын хойд хилийн Олон Улсын эрх зүйн баталгаажуулалт байхгүй байгаа нь хилийн дэглэм, журамд тавигдах үндсэн шаардлагуудыг боловсруулан хэрэгжүүлэх процесст сайнгүй нөлөө үзүүлж байна.

Дүгнэлт:

Хил дээр болон хилийн орон зайд үндэсний ашиг сонирхлыг хамгаалах нь олон улсын эрх зүйн, эдийн засгийн, улс төрийн, гаалийн, цагаачлалын, байгалийн, алба-байлдааны болон бусад арга хэмжээ, үйл ажиллагааны нийлмэл цогцолборыг бүрдүүлдгийг тооцон, хилийн орон зайд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын тэр дундаа төрийн захиргааны байгууллагуудын бүрэн эрх, чиг үүргийг тодорхой болгох нь онцгой чухал төдийгүй тэдний үйл ажиллагааг маш тодорхой зохицуулж уялдуулах шаардлагатай тулгарч байна.

Санал:

Өнөөдөр зөвхөн улсын хил дээр үйл ажиллагаа явуулснаар үндэсний ашиг сонирхолын, тэр тусмаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, түүний хилийн халдашгүй дархан байдлын хамгаалалтыг хангах боломжгүй. Монгол Улсын асуудал болон хилийн асуудал зөвхөн хилийн хоёр талаар өргөн зурваст, өөрөөр хэлбэл хилийн орон зайд хилийн хамгаалалтын бүх субъектуудын идэвхитэй үйл ажиллагааны нөхцөлд амжилттай шийдвэрлэгдэж чаднах учир энэ тал дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт:

Арвай.Ш Хилийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны тулгамдсан зарим асуудал(Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа/Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал/).УБ.2012 он.

Нямдорж.Д Улсын хилийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд, системийн онолтой холбогдох нь(Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа /Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал/).УБ.2012 он.

Монгол Улсын Хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он №06.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он.